

“Тунгалаг Тамир” роман дахь Рене Жирарын “Гурвалжин хүслийн онол”

Тифэн Канн / Turhaine Cann
(МУИС-ийн Улаанбаатар сургуулийн докторант)

Түлхүүр үг: “гурвалжин хүсэл”, “дүрлэл дууриамалийн хүслийн” онол, Р.Жирар, Ч.Лодойдамба, Тунгалаг Тамир, Багш шавийн барилдлага, утга зохиол.

Хураануй

Уран зохиолын шилдэг хэдэн бүтээл туурвилийн жишээнд анх тулгуурсан Франц философич, түүхч, хүн судлаач Рене Жирарын “дүрлэл дууриамлын хүсэл” хэмээн онол нь хүн төрөлхтний дунд хүчирхийллийн харилцаа юунаас үүсдэг вэ гэхэд тайлагдаг зорилготой бөгөөд хүчирхийлэл нь бахархахын зэрэгцээ атаархлаас үүсдэг гэж Жирар дүгнэжээ. Бид энэхүү өгүүлэлдээ Жирарын онолыг авч үзээд Ч. Лодойдамбын Тунгалаг Тамир романы дүрүүдийн хоорондын харилцаа задлан шинжилсэн болно.

Жирарын хувьд багш шавийн барилдлага бол бишрэн бахархалд үндэслэсэн боловч бахархал атаархал хоёрын хоорондын зай үлэмж нимгэн бөгөөд эл хоёрын хооронд атаархал дийлвэл хүндэтгэн хайрлахын оронд шавь нь багшийгаа үзэн ядаж өөрийнхөө өстөн дайсныг гэж үздэг болно. М. Сервантесийн Дон Кихот, Г. Флобер “Бовари хатагтай”, Стендалийн “Улааныхан ба харынхан”, М. Прустын “Алдагдсан цагийн эрэлд” болон Ф. Достоевскийгийн “Записки из подполья”, “Вечный муж”, “Подросток” зэрэг бүтээлүүдийг жинжилж судалсан Жирар нь “зуучлал” хэмээн ойлголтыг зохион болгосон. Үүнээс хоёр янзын хувилбарыг ялгасан байна. “гадаад зуучлал” бол багш шавийн хоорондын зай ялгаа маш өргөн болохоор атаархал үүсэж болохгүй шавь нь багшийгаа хүндэтгэн дууриалан хайрладаг. Гэтэл ард эрхтэй нийгэмд хүн хүний хоорондын тус зай ялгаа нимгэн болох тутам шавь нь багшийгаа өөрийнхөө үлгэр гэж үзсэнээ больж түүнд байдаг бүр зүйлүүдийг хүсдэг болоод бөгөөд хамтран эзэлж болохгүй учраас хайрлахын оронд үзэн багшийгаа үзэн яддаг болдог юм. Мөн Жрарын онолд багшдаа байгаа тэр зүйл нь чухал бус бөгөөд өөрчилж болно харин “хүсэл” үргэлж хэвээрээ.

Энэхүү онолыг авч үзюэл монгол нэр хүндтэй Ч. Лодойдамбын ТунгалагТамир хэмээн шилдэг романы Итгэл/Эрдэнэ/Долгор дүрүүдийн хооронд харилцааг задлан шинжилж зорисон болно.